

## **ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙГ УДИРДАХ СИСТЕМ**

2008 оны 2-р сарын 28-нд Засгийн газраас баталсан 58 тоот журам

РТ11, 5.03.08, 12, 84

2008 оны 3-р сарын 8-нд хүчин төгөлдөр болсон.

Энэхүү журам нь Олон нийтийн мэдээллийн тухай хуулийн 433 (5) ба 437 (1) хэсэг, 439 (1) б)-р зүйлд үндэслэсэн болно.

### **1-Р БҮЛЭГ**

#### **Нийтлэг үндэслэл**

#### **§ 1. Үйлчлэх хүрээ**

Энэхүү журмаар дараахи зүйлийг зохицуулна:

- 1) төрийн мэдээллийн системийг удирдах систем;
- 2) Төрийн мэдээллийн системийг удирдан ажиллуулах үүднээс мэдээллийн системд өгөгдлийн санг бүртгэх журам;
- 3) өгөгдлийн сангийн техникийн баримт бичигт зөвшөөрөл олгох нөхцөл, журам(үүнээс хойш өгөгдлийн сангийн баримт бичиг гэх);
- 4) өгөгдлийн сан байгуулахад тавигдах захиргааны шаардлага;
- 5) төрийн мэдээллийн системийг удирдан ажиллуулахад шаардагдах мэдээллийн системийг ажиллуулах журам

#### **§ 2. Төрийн мэдээллийн системийг удирдах систем**

Төрийн мэдээллийн системийг удирдах систем нь төрийн мэдээллийн системийг удирдан ажиллуулах мэдээллийн систем (ТМСУАМС гэх) болон төрийн мэдээллийн системийг удирдан ажиллуулах зарчмуудаас бүрдэнэ.

#### **§ 3. Төрийн мэдээллийн системийг удирдах системийн зорилт**

Төрийн мэдээллийн системийг удирдах системийн зорилт нь төрийн мэдээллийн системийг удирдан ажиллуулах ил тод байдал, мэдээллийн удирдлагын төлөвлөлт болон улсын ба орон нутгийн захиргааны байгууллагуудын өгөгдлийн сангууд, түүнчлэн нийтийн ажил үүрэг гүйцэтгэж буй хувь этгээдийн өгөгдлийн сангуудын уялдан ажиллах нөхцлийг хангах явдал юм.

#### **§ 4. Нэр томъёо**

- (1) Өгөгдөл гэж Хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд заасан агуулгын хүрээнд хамаарах хувийн өгөгдөл, эсхүл засгийн газрын болоод орон нутгийн засаг захиргаа,

тэрчлэн нийтийн албаны чиг үүрэг гүйцэтгэж буй хувийн эрх зүйн этгээдээс ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой өгөгдлийн санд боловсруулагдсан бусад өгөгдлийг ойлгоно.

(2) Өгөгдлийн бүтэц гэдэг нь засгийн газар, орон нутгийн засаг захиргаа болон нийтийн эрх зүйн бусад этгээдүүдийн нийтийн албаны чиг үүргээ гүйцэтгэхэд зориулан боловсруулсан өгөгдлүүдийн зохион байгуулалттай бүтэц юм.

(3) Өгөгдлийн сан гэдэг нь засгийн газар, орон нутгийн засаг захиргаа болон нийтийн эрх зүйн бусад этгээдүүд, тэрчлэн нийтийн албаны чиг үүрэг гүйцэтгэж буй хувийн эрх зүйн этгээдүүдийн мэдээллийн системийн хүрээнд боловсруулагдсан, зохион байгуулалттай өгөгдлүүдийн цогц юм.

(4) Өгөгдлийн объект гэдэг нь мэдээллийн системд өгөгдлийг боловсруулахтай холбоотой хүн, юм, үйл явдал буюу тэдгээрийн хоорондох холбоосыг хэлнэ.

## **§ 5. Төрийн мэдээллийн системийг удирдан ажиллуулах зарчим**

(1) Төрийн мэдээллийн системийг удирдан ажиллуулахдаа төрийн мэдээллийн системийн уялдан ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн дараахи зарчимд үндэслэнэ:

1) хууль ёсны байх зарчим – Хууль, түүнд үндэслэн гаргасан бусад хууль тогтоомж, эсхүл олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх явцад нийтийн албаны чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой өгөгдлүүд нь төрийн мэдээллийн системд харьяалагдах өгөгдлийн санд боловсруулагдсан байна.

2) нэгдмэл байх зарчим – төрийн мэдээллийн системд харьяалагдах өгөгдлийн сангууд нь өөр хоорондоо зохицон ажиллах боломжтой, өгөгдлийг харилцан солилцох, нягтлан шалгах чадвартай байна.

3) үндсэн өгөгдлийг ашиглах зарчим- өгөгдлийг аль болох жинхэнэ эх сурвалжаас цуглуулах бөгөөд тухайн өгөгдлийг өгөгдлийн санд хадгална. Тэрхүү өгөгдлийн сан нь хуулиар тогтоосон үүргийн дагуу төрийн мэдээллийн системд харьяалагдаж байгаа бүх өгөгдлийн санд нийтлэг эх сурвалж болох ёстой.

4) эх үүсвэр нь тодорхой байх зарчим-өгөгдлийн санд хандсан бүх хандалт болон хэрэглэгчдэд өгсөн хариултыг хадгална. (мэдээллийн системүүд нь аюулгүй серверийн аюулгүйн байдлын тэмдэглэл (security logs)-үүдийн хүрээнд өгөгдөл солилцох давхаргатай интерфейс хийсэн тохиолдолд).

5) мэдээллийн технологийн сүүлийн үеийн ололтыг ашиглах зарчим – төрийн мэдээллийн системд харьяалагдах өгөгдлийн санг удирдан ажиллуулахдаа

мэдээллийн технологийн сүүлийн үеийн ололтыг дээд зэргээр ашиглана. Өгөгдлийг тоон хэлбэрээр боловсруулна.

б) өгөгдлийг солилцох үйлчилгээнд суурилсан хандлага- өөр өөр өгөгдлийн сангууд ба процессоруудын хооронд өгөгдлийг солилцохдоо (солбицон хэрэглэх) өгөгдлийн үйлчилгээнд үндэслэн явуулна.

7) техникийн ба зохион байгуулалтын оновчтой байдлын зарчим- аливаа өгөгдлийн санг үүсгэх буюу өөрчлөхдөө төрийн мэдээллийн системийг удирдан ажиллуулах зарчмууд, тухайн салбарын тэргүүн туршлага, Эдийн засгийн асуудал ба харилцаа холбооны яамнаас баталсан төрийн мэдээллийн технологийн уялдан ажиллах тухай баримт бичиг зэрэгт үндэслэн явуулна.

(2) 1-р дэд хэсэгт заасан зарчмуудаас гадна Хувийн өгөгдлийг хамгаалах тухай хуулийн 6-р зүйлд заасан хувийн өгөгдлийг боловсруулах зарчмуудыг төрийн мэдээллийн системд хувийн өгөгдлийг боловсруулахдаа мөрдлөг болгоно.

## **2-Р БҮЛЭГ**

### **Өгөгдлийн сангийн баримт бичиг**

#### **§ 6. Өгөгдлийн сангийн баримт бичгийг бэлтгэх**

(1) Өгөгдлийн санг үүсгэх буюу өгөгдлийн санд цуглуулсан өгөгдлийн бүтцийг өөрчлөхдөө өгөгдлийн санг үүсгэгч буюу ерөнхий хариуцагч (chief processor) нь одоо байгаа өгөгдлийн санд шаардлагатай өгөгдлүүд аль хэдийнэ цугларсан эсэхийг шалгавал зохино.

(2) Ийнхүү шалгасны дүнд хэрэгцээтэй өгөгдлийг цуглуулах, боловсруулахын тулд эсхүл одоо байгаа өгөгдлийн санд цугларсан өгөгдлийн бүтцийг өөрчлөхийн тулд шинээр өгөгдлийн сан үүсгэх шаардлагатай болох нь тогтоогдвол өгөгдлийн санг үүсгэгч буюу ерөнхий хариуцагч нь өгөгдлийн сангийн баримт бичгийг бэлтгэнэ.

(3) Өгөгдлийн сангийн баримт бичиг нь 18 (2) 1)–22), 24) ба 26)–28)-р зүйл, мөн (3), (4), 19 (2), 20 (2), 22 (2)-р дэд хэсэгт заасан өгөгдлийн бүтэцтэй дүйцэх өгөгдөл болон энэхүү журмын 26-р зүйлд дурдсан Хуульд заасан өгөгдлөөс бүрдэнэ.

(4) Хэрэв шалгалтын дүнд хэрэгцээтэй өгөгдөл одоо байгаа өгөгдлийн санд аль хэдийнэ цугларсан болох нь тогтоогдвол шинэ өгөгдлийн санг үүсгэгч этгээд ТМСУАМС-аар дамжуулан тухайн өгөгдлийн сангийн ерөнхий хариуцагчид хандан уг өгөгдлийг төрийн мэдээллийн системд ашиглахыг хүссэн өргөдөл гаргана.

## **§ 7. Өгөгдлийн сангийн бичиг баримтад зөвшөөрөл олгох**

(1) Өгөгдлийн санг үүсгэгч солигдсон эсхүл өгөгдлийн санд цуглуулсан өгөгдлийн бүтэц өөрчлөгдсөн тохиолдолд ерөнхий хариуцагч өгөгдлийн сангийн баримт бичгийг энэхүү журмын (2)-(4) дэд хэсэгт заасан шаардлагын дагуу ТМСУАМС-ээр дамжуулан Эдийн засгийн асуудал ба харилцаа холбооны яам, Өгөгдөл хамгаалах ерөнхий газар болон Статистийн газарт тус тус хүлээлгэн өгнө.

(2) Хэрэв өгөгдлийн санг зөвхөн аль нэг байгууллага буюу байгууллага хоорондын бичиг баримтыг боловсруулах дотоод дүрэм журмын хэрэгцээг хангах зорилгоор үүсгэсэн эсхүл уг өгөгдлийн сан өгөгдлийн сангийн солилцооны давхарга Х-Тее (X-Road)-д холбогдохгүй тохиолдолд өгөгдлийн сангийн баримт бичигт Эдийн засаг, харилцаа холбооны яамнаас зөвшөөрөл авах шаардлагагүй.

Аливаа байгууллагын дотоод дүрэм журмын хэрэгцээг хангах зорилгоор ашиглагдаж байгаа өгөгдлийн сан гэдэг нь бусад хэрэгцээ шаардлагыг хангах үүднээс гадагш гаргаснаас бусад тухайн байгууллагын хууль тогтоомж болон байгууллагын бусад баримт бичигт заасан байгууллагын үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор хадгалагдаж байгаа өгөгдлийн сан мөн.

Агентлаг хоорондын бичиг баримт боловсруулах зорилгоор ашиглах өгөгдлийн сан нь Нийтийн өгөгдлийн тухай хуулийн 11-р зүйлд заасан агентлагийн баримт бичгийн бүртгэл байна.

(3) Гагцхүү тухайн байгууллагын дотоод дүрэм журмын шаардлагыг хангах зорилгоор эсхүл агентлаг хоорондын баримт бичгийг боловсруулах зорилгоор үүсгэсэн өгөгдлийн сангийн баримт бичгийн тухайд Өгөгдлийн санг хамгаалах хяналтын газраас зөвшөөрөл авах шаардлагагүй.

(4) Аливаа өгөгдлийн сангийн баримт бичигт Албан ёсны статистикийн хуулийн 5 (11) дэд хэсэгт заасны дагуу Статистикийн газраас зөвшөөрөл олгох ёстой.

(5) Өгөгдлийн сангийн баримт бичигт зөвшөөрөл олгосноор Эдийн засаг, харилцаа холбооны яам уг өгөгдлийн сангийн техникийн үзүүлэлт, цуглуулсан өгөгдлийн бүтэц болон тэдгээрийн эх сурвалж зэрэг хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг үнэлэхээс гадна ямар төрлийн үндсэн өгөгдлийг уг өгөгдлийн санд цуглуулсан болохыг нягтлан шалгана.

(6) Өгөгдөл хамгаалах хяналтын газар (Data Protection Inspectorate) өгөгдлийн сангийн баримт бичигт зөвшөөрөл олгохдоо зохион байгууллалтын болон мэдээллийн технологийн шаардлага, түүний дотор цуглуулсан өгөгдлийн бүтэц болон эх сурвалж Нийтийн өгөгдлийн тухай хууль нийцэж байгаа эсэх, хамгийн гол нь өгөгдлийн санд байгаа өгөгдлийг ашиглахад хязгаарлалт тогтоох шаардлагатай эсэх эсхүл өгөгдлийн санд байгаа өгөгдлийг ил тод болгосноор хүлээх үүрэгт хязгаарлалт тогтоох шаардлагатай эсэх, тэрчлэн Хувийн өгөгдлийг хамгаалах тухай хуульд заасан шаардлага болон хамгийн гол нь хувийн өгөгдлийг боловсруулах зарчмууд, өгөгдлийн аюулгүй байдлын ангилал, аюулгүй байдлын арга хэмжээ зэрэгт үнэлгээ өгч, нягтлан шалгана.

(7) (1) дэд хэсэгт дурдсан эрх бүхий байгууллага баримт бичигт үндэслэлтэй тайлбар гарган зөвшөөрөл олгох буюу татгалзах эрхтэй. Ингэхдээ өгөгдлийн сангийн зөвшөөрөл хүссэн баримт бичгийг ирүүлснээс 20 хоногийн дотор шийдвэрлэнэ.

(8) Өгөгдлийн сангийн баримт бичгийг хүлээн авсан (1) дэд хэсэгт дурдсан эрх бүхий бүх байгууллага зөвшөөрөл олгосноор өгөгдлийн сангийн баримт бичиг зөвшөөрөгдсөн гэж үзнэ.

(9) Хэрэв өгөгдлийн сангийн баримт бичигт зөвшөөрөл олгосны дараа, өгөгдлийн санд цугласан өгөгдлийн бүтцийн өөрчлөлтийг бүртгэхээс өмнө түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан бол уг баримт бичигт (1) дэд хэсэгт заасан эрх бүхий байгууллагаас дахин зөвшөөрөл авахыг хүсч өргөдөл гаргана.

(10) Аливаа өгөгдлийн санг үүсгэгч нь өгөгдлийн санг үүсгэхдээ эсхүл ерөнхий хариуцагч өгөгдлийн санд цугласан өгөгдлийн бүтцийг өөрчлөхдөө батлагдсан баримт бичигт нийцүүлнэ.

(11) Хэрэв өгөгдлийн санг хэрэглэж эхлэх буюу өгөгдлийн санд цугласан өгөгдлийн бүтцийг өөрчлөхөд нийтийн худалдан авалт хийх шаардлагатай бол нийтийн худалдан авалтыг зарлахаас өмнө өгөгдлийн сангийн баримт бичгийг батлуулах шаардлагатай бөгөөд нийтийн худалдан авалтын баримт бичиг нь өгөгдлийн сангийн батлагдсан баримт бичигт үндэслэнэ.

## **§ 8. Өгөгдлийн сангийн баримт бичигт зөвшөөрөл олгохоос татгалзах**

(1) Өгөгдлийн сангийн баримт бичгийг батлахаас татгалзах тохиолдолд тийнхүү татгалзсан шалтгааны талаар өгөгдлийн санг үүсгэгчид мэдэгдэх ёстой бөгөөд тэдгээр

шалтгааныг арилгасны дараа шинэчлэн өөрчилсөн баримт бичигт зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргаж болно.

(2) 7 (1) дэд хэсэгт заасан зөвшөөрлийг авалгүйгээр өгөгдлийн санг үүсгэх буюу өгөгдлийн сангийн бүрэлдэхүүн дэх өгөгдлийн бүтцийг өөрчилж болохгүй.

### **3-Р БҮЛЭГ**

#### **Төрийн мэдээллийн системийг удирдан ажиллуулах**

##### **мэдээллийн системийн өгөгдлийг бүртгэх**

#### **§ 9. ТМСУАМС –д бүртгэх өгөгдлийн сангууд**

(1) Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа буюу нийтийн эрх зүйн бусад этгээд эсхүл нийтийн албаны чиг үүргийг хэрэгжүүлж буй хувийн эрх зүйн этгээдийн бүх өгөгдлийн санг ТМСУАМС-д бүртгэнэ.

(2) Төрийн нууцын тухай хууль болон Гадаад улсуудын нууц мэдээллийн тухай хуульд заасны дагуу хандалтыг нь хязгаарласан өгөгдлийн сангуудыг ТМСУАМС-д бүртгэхгүй.

(3) ТМСУАМС-д бүртгэгдсэн өгөгдлийн сангуудыг төрийн мэдээллийн системд харьяалагдах ба төрийн мэдээллийн системд үл харьяалагдах өгөгдлийн сан гэж ангилна.

(4) ТМСУАМС-д бүртгэгдсэн бөгөөд мэдээллийн системүүдийн өгөгдөл солилцооны давхарга (үүнээс хойш Х-Тее гэх)-тай интерфес хийгдсэн өгөгдлийн сангууд нь төрийн мэдээллийн системд харьяалагдана.

#### **§ 10. Өгөгдлийн сангуудыг бүртгэх ба ТМСУАМС-ийн өгөгдлийн сангуудад цуглуулсан өгөгдлийн бүтцэд хийгдсэн өөрчлөлтийг бүртгэх**

(1) Эдийн засаг, харилцаа холбооны яамнаас эрх олгогдсон төрийн албан хаагч эсхүл уг яамны харьяа агентлагийн албан хаагч (үүнээс хойш ТМСУАМС-ийн администратор гэх) ТМСУАМС-ийн өгөгдлийн сангуудын бүртгэл болон өгөгдлийн сангуудад цугласан өгөгдлийн бүтцэд хийгдсэн өөрчлөлтийг бүртгэх ажлыг тус тус зохион байгуулна.

(2) Өгөгдлийн сангийн ерөнхий хариуцагч нь өгөгдлийн сангуудыг бүртгүүлэх эсхүл ТМСУАМС дахь өгөгдлийн санд цугласан өгөгдлийн бүтцэд хийгдсэн өөрчлөлтийг бүртгүүлэх өргөдлийг өгөгдлийн сангуудыг бүртгэх буюу өгөгдлийн санд цугласан өгөгдлийн бүтцэд хийгдсэн өөрчлөлтийг бүртгэх үндсийг тогтоосон хууль тогтоомж

батлагдсаны дараа чингэхдээ уг хууль тогтоомжийг хүчин төгөлдөр болсноос хойш 10 хоногоос хэтрүүлэлгүйгээр гаргах ёстой.

(3) Өгөгдлийн санг бүртгүүлэх эсхүл өгөгдлийн санд цугласан өгөгдлийн бүтцэд хийгдсэн өөрчлөлтийг бүртгүүлэхдээ уг өгөгдлийн санг хариуцаж буй ажилтан 18 (2) 1)–22), 24) болон 26)–28) дугаар зүйл, (3) , (4), 19 (2), 20 (2), 22 (2) дугаар дэд хэсгүүд болон Хуулийн § 26-р зүйлд заасан бүх өгөгдлийг шинэчлэх ёстой.

(4) Өгөгдлийн санг бүртгүүлэх эсхүл өгөгдлийн санд цугласан өгөгдлийн бүтцэд хийгдсэн өөрчлөлтийг бүртгүүлэхийн өмнө ТМСУАМС-ийн администратор уг өгөгдлийн сан нь §§ 7 ба 8-р зүйл заасан журмын дагуу зөвшөөрөл авсан өгөгдлийн сангийн баримт бичигтэй нийцэж буй эсэхийг ажлын 20 хоногийн дотор нягтлан шалгана.

(5) Гагцхүү байгууллагын дотоод дүрэм журмын хэрэгцээг хангах эсхүл Х-Тее-тэй интерфейс хийгдэхгүй агентлаг хоорондын баримт бичгийг боловсруулах зорилгоор үүсгэсэн өгөгдлийн санг бүртгэхдээ ТМСУАМС-ийн администратор тухайн өгөгдлийн сан техникийн шаардлага хангаж байгаа эсэх, цуглуулсан өгөгдлийн бүтэц ба эх сурвалж холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгана.

(6) Ийнхүү нягтлан шалгасны эцэст ТМСУАМС-ийн администратор өгөгдлийн сан буюу ТМСУАМС дахь өгөгдлийн санд цугласан өгөгдлийн бүтцэд хийгдсэн өөрчлөлтийг бүртгэнэ.

(7) ТМСУАМС-ийн администратор төрийн мэдээллийн системд харьяалагдах өгөгдлийн санд хадгалагдаж буй үндсэн өгөгдөлд орсон өөрчлөлтийн талаар ТМСУАМС-ийн үйлчилгээгээр дамжуулан бүртгэлтэй бүх хэрэглэгчдэд мэдэгдэнэ.

### **§ 11. ТМСУАМС дахь өгөгдлийн сангийн бусад өөрчлөлтийг бүртгэх**

Өгөгдлийн санд цуглуулсан өгөгдлийн бүтэцтэй холбоотой биш өгөгдөлд хийгдсэн өөрчлөлтийг § 7-р зүйлд заасан журмын дагуу бүртгэх шаардлагагүй.

### **§ 12. Өгөгдлийн сангийн үйл ажиллагааг зогсоосон тухай бүртгэх**

(1) Өгөгдлийн сангийн үйл ажиллагааг зогсоохдоо өгөгдлийг өөр өгөгдлийн сан буюу архивт шилжүүлэх буюу устгах, тийнхүү шилжүүлэх буюу устгахад шаардагдах хугацааг тогтооно. Өгөгдлийг шилжүүлэх буюу устгахдаа холбогдох хууль эрх зүйн баримт бичгийг бэлтгэх бөгөөд өгөгдлийн сангийн үйл ажиллагаа дуусгавар болсныг бүртгэсний дараа ТМСУАМС-д оруулна.

(2) Өгөгдлийн сангийн ерөнхий хариуцагч ТМСУАМС-ээр дамжуулан Эдийн засаг, харилцаа холбооны яам, Өгөгдөл хамгаалах хяналтын газар болон Статистикийн газраас өгөгдлийн сангийн ажиллагааг зогсоох зөвшөөрөл авна.

Эдийн засаг, харилцаа холбооны яам болон Өгөгдөл хамгаалах хяналтын газар нь холбогдох эрх бүхий төлөөлөгчдийг байлцуулан тухайн өгөгдлийн санг шилжүүлэх эсхүл устгах хүсэлт гаргах эрхтэй.

(3) ТМСУАМС-ийн администратор нь өгөгдлийн сангийн ажиллагааг зогсоосны дараа “өгөгдлийн сангийн ажиллагааг зогсоосон” гэсэн тэмдэглэгээ хийнэ.

### **§ 13. Өгөгдлийн санг бүртгэхээс татгалзах**

(1) ТМСУАМС-ийн администратор нь хэрэв өгөгдлийн сан эсхүл ТМСУАМС дахь өгөгдлийн сангийн өгөгдлийн бүтцийн өөрчлөлт нь хууль тогтоомж болон тэдгээрт үндэслэн гарсан дүрэм журмын шаардлагад нийцэхгүй бол тухайн өгөгдлийн сан буюу өгөгдлийн сангийн өгөгдлийн бүтцийн өөрчлөлтийг бүртгэхээс хүндэтгэх шалтгаанаар татгалзаж болно.

(2) Өгөгдлийн санг үүсгэгч буюу ерөнхий хариуцагч нь бүртгэхээс татгалзах шалтгаан болсон алдаа дутагдлыг арилгаж, ТМСУАМС-д өгөгдлийн санг бүртгүүлэх өргөдлийг ахин гаргана.

(3) ТМСУАМС-д бүртгэгдээгүй өгөгдлийн санг ашиглаж болохгүй.

## **4-Р БҮЛЭГ**

### **ТМСУАМС-ийг ажиллуулах журам**

#### **§ 14. ТМСУАМС-ийн зорилт**

ТМСУАМС-ийн зорилт нь төрийн мэдээллийн системийг удирдан ажиллуулах ажлыг дэмжих явдал мөн.

#### **§ 15. ТМСУАМС-ийн ерөнхий хариуцагч**

ТМСУАМС-ийн ерөнхий хариуцагч нь Эстонийн Мэдээллийн технологийн төв байна.

#### **§ 16. ТМСУАМС-ийн ерөнхий хариуцагчийн үүрэг**

(1) Эстонийн Мэдээллийн технологийн төв нь төрийн мэдээллийн системийн ерөнхий хариуцагчийн хувьд дараахи үүргийг хүлээнэ:

- 1) ТМСУАМС-ийн хэвийн ажиллагаа, хөгжлийг хангах;

- 2) ТМСУАМС-ийн үүрэг функцээс үүдэн гарч буй өгөгдлийн үйлчилгээг нэвтрүүлэх
- 3) Хязгаарлалт тогтоогоогүй ТМСУАМС-ийн өгөгдөлд чөлөөтэй нэвтрэх боломжийг хангах
- 4) Өгөгдлийн сан үүсгэсэн тухай болон тэдгээрийг ТМСУАМС-д бүртгэх асуудлаар өгөгдлийн сан үүсгэгчид болон ерөнхий хариуцагчидтай зөвлөлдөх
- 5) ТМСУАМС-ийн хэрэглэгчийг дэмжих үйлчилгээний үйл ажиллагааг хангах
- 6) ТМСУАМС-ийг байрлуулах ажлыг зохион байгуулах
- 7) ТМСУАМС-ийн аюулгүй ажиллагааг хангах
- 8) ТМСУАМС-ийн өндөр чанартай хэрэглэгчийг дэмжих үйлчилгээ үзүүлэх
- 9) Хууль тогтоомжоор олгогдсон бусад үүрэг функцийг хэрэгжүүлэх

(2) ТМСУАМС-ийн ерөнхий хариуцагч нь ТМСУАМС-ийн хариуцан ажиллуулж байгаа толь бичиг болон утгачилсан талбарын дэд-системийн бүтцийн удирдамж болон өгөгдлийн сангуудын утгачилсан тодорхойлолтын удирдамжийг боловсруулах, тэдгээр удирдамжийг Эдийн засаг, харилцаа холбооны яамаар батлуулж, өөрийн вэб хуудсанд нийтлэх.

(3) ТМСУАМС-ийн ерөнхий хариуцагч нь дараахи зүйлст Эдийн засаг, харилцаа холбооны яамнаас урьдчилж зөвшөөрөл авна:

- 1) ТМСУАМС-ийн өгөгдлийн бүтэц дэх өгөгдлийн утга агуулга болон хэлбэрийг нарийвчлан заах, тодорхойлох буюу өөрчлөхтэй холбоотой удирдамж
- 2) ТМСУАМС-ийн өгөгдлийн бүтэц дэх өгөгдлийн утга агуулга болон хэлбэрийг нарийвчлан заах, тодорхойлох буюу өөрчлөхтэй холбоотой ТМСУАМС-ийг хөгжүүлэх ажил

## **§ 17. ТМСУАМС-ийн бүтэц зохион байгуулалт**

(1) ТМСУАМС-ийн дотоод бүрэлдэхүүн хэсгүүд нь ТМСУАМС-ийн хэрэглэгчийн интерфейс, ТМСУАМС-ийн үйлчилгээний интерфейс болон ТМСУАМС-ийн өгөгдлийн сан байна.

(2) ТМСУАМС-ийн гадаад бүрэлдэхүүн хэсгүүд нь тулгарсан асуудлыг шийдвэрлэх асуудлыг багтаасан хэрэглэгчийг дэмжих систем, өөрчлөлт ба хяналтын систем зэрэг байна.

(3) ТМСУАМС-ийн өгөгдлийн сангийн бүтцэд дараахи дэд-бүртгэлийн сан харьяалагдана:

- 1) өгөгдлийн сангийн дэд-бүртгэлийн сан
- 2) агентлагуудын дэд-бүртгэлийн сан
- 3) холбоо барих этгээдийн дэд-бүртгэлийн сан
- 4) зөвшөөрлийн дэд-бүртгэлийн сан
- 5) X-Тее-д интерфейс хийгдсэн дэд-бүртгэлийн сан
- 6) өргөдлийн дэд-бүртгэлийн сан
- 7) мэдэгдлийн дэд-бүртгэлийн сан
- 8) үйлчилгээний дэд-бүртгэлийн сан
- 9) ангиллын дэд-бүртгэлийн сан
- 10) утгачилсан талбарын дэд-бүртгэлийн сан

#### **§ 18. ТМСУАМС-ийн өгөгдлийн сангуудын дэд-бүртгэлийн сан**

(1) (2) ба (4-) -р зүйлд дурдагдсан өгөгдлүүдийн тухайд ТМСУАМС-ийн өгөгдлийн сангуудын дэд-бүртгэлийн санд дараахи өгөгдлийн сангуудыг оруулна:

- 1) X-Тее болон бусад өгөгдлийн сангуудаар дамжуулан мэдээлэл солилцох өгөгдлийн сангууд
- 2) агентлаг хоорондын баримт бичгийг боловсруулах шаардлагыг хангах үүднээс ажиллуулж буй өгөгдлийн сангууд

(2) ТМСУАМС-ийн өгөгдлийн сангуудын дэд-бүртгэлийн санд оруулах өгөгдлийн сангийн тухай ерөнхий өгөгдлийн бүтэц:

- 1) өгөгдлийн сангийн нэр, товчлол, англи нэр (хэрэв байгаа бол)
- 2) Өгөгдлийн сангийн ажиллагааны төлвийг илтгэсэн тэмдэглэгээ
- 3) Өгөгдлийн сан үүсгэх эрх зүйн үндэслэл
- 4) Өгөгдлийн сангийн зорилго, үүрэг функц
- 5) Өгөгдлийн сангийн харилцан ажиллагаанд тавигдах шаардлага, ажиллагааны дүрэмд нийцсэн бүтцийн тайлбар, үйл ажиллагааны явц болон өгөгдлийн сангийн бусад чухал шаардлагатай техникийн тайлбарыг багтаасан баримт бичгүүд, өгөгдлийн сангийн талаарх хууль тогтоомжууд эсхүл хууль тогтоомжийн төслүүд
- 6) Өгөгдлийн сангийн ерөнхий болон эрх бүхий хариуцагчдын нэрс
- 7) Өгөгдлийн сангийн ерөнхий болон эрх бүхий хариуцагчдын бүртгэлийн код
- 8) Өгөгдлийн сан үүсгэсэн огноо
- 9) Өгөгдлийн санг ажиллуулж эхэлсэн огноо

- 10) Өгөгдлийн санг X-tee-д интерфейс хийгдсэн огноо
  - 11) хувийн болон хувийн нууц өгөгдөл өгөгдлийн санд боловсруулагдах эсэх
  - 12) Өгөгдлийн санд өгөгдлийг архивласан арга
  - 13) Өгөгдлийн санд хамгийн сүүлийн өгөгдөл цуглуулах цаг хугацаа
  - 14) Өгөгдөл болон өгөгдлийн сан дахь баримт бичгийн эх сурвалжийг хадгалах хугацаа (хадгалах хугацааг жилээр тогтоож өгнө)
  - 15) Өгөгдлийн сангийн өгөгдлийг шинэчлэх давтамж
  - 16) Өгөгдлийн сангийн аюулгүй байдлын ангилал
  - 17) Өгөгдлийн сангийн аюулгүй байдлын төвшин
  - 18) Мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх эрэмбэ
  - 19) Өгөгдлийн санд ашигласан стандартууд
  - 20) Өгөгдлийн санд ашиглаж, хэрэгжүүлсэн ангилал
  - 21) Өгөгдлийн сан нь төрийн мэдээллийн санд харьяалагддаг болохыг илтгэсэн тэмдэглэгээ
  - 22) Өгөгдлийн сангуудын зохион байгуулалтын бүлгийн нэр
  - 23) Өгөгдлийн сан болон түүний хэрэглээний талаарх статистикийг хянах өгөгдөл
  - 24) Өгөгдлийн сангийн үйлчилгээний төвшний үзүүлэлтүүд
  - 25) Өгөгдлийн санг ашиглаж байх хугацаанд тохиолдсон хүндрэлтэй асуудлуудын жагсаалт
  - 26) Өгөгдлийн бүтэц, түүний лавлах материалыг өөрчлөх эрх зүйн үндэслэл
  - 27) Өгөгдлийн бүтцийг өөрчлөх ажлын эхлэл
  - 28) Өгөгдлийн бүтцийг өөрчлөхтэй холбогдон гарсан бусад өөрчлөлт
- (3) ТМСУАМС-ийн өгөгдлийн сангийн дэд-бүртгэлийн санд оруулах өгөгдлийн санд боловсруулагдсан өгөгдөл нь дараах бүтэцтэй байна. Үүнд:
- 1) Өгөгдлийн объектын нэр, лавлагаа хэлбэрээр оруулсан өгөгдлийн утгачилсан тайлбар
  - 2) Өгөгдлийн объектын талаарх дэлгэрэнгүй өгөгдлийн жагсаалт, дэлгэрэнгүй өгөгдлийн утгачилсан тайлбар
  - 3) Тухайн өгөгдөл нь хувийн эсхүл хувийн нууц өгөгдөл эсэхийг илтгэсэн тэмдэглэгээ

- 4) Үндсэн мэдээллийн жагсаалт
- 5) Үндсэн бус өгөгдлийн эх сурвалжийн талаарх лавлагаа
- 6) Архивлагдах өгөгдлийн жагсаалт

(4) Өгөгдлийн санд мэдээлэл үүсгэж, боловсруулах үндсийг тогтоож буй хууль тогтоомжтой холбоотой ТМСУАМС-ийн дэд-бүртгэлийн санд оруулах өгөгдлийн бүтэц дараахи хэлбэртэй байна:

- 1) хууль тогтоомжийн нэр
- 2) хууль тогтоомжийг баталсан этгээд, түүний төрөл
- 3) дугаар, өгөгдөл, хууль тогтоомжийг хэвлэсэн тухай лавлагаа, баримт бичгийг лавлах URL хаяг, эсхүл уг баримт бичиг өөрөө
- 4) хууль тогтоомж хүчин төгөлдөр эсэх

#### **§ 19. ТМСУАМС-ийн агентлагуудын дэд-бүртгэлийн сан**

(1) Ерөнхий болон эрх бүхий хариуцагчдын мэдээлэл болон ТМСУАМС-д бүртгүүлсэн өгөгдлийн сангийн үйлчилгээг ашиглаж буй агентлагуудыг ТМСУАМС-ийн агентлагуудын дэд-бүртгэлийн санд оруулна.

(2) ТМСУАМС-ийн агентлагуудын дэд-бүртгэлийн санд оруулах шаардлагатай агентлагуудын талаарх ерөнхий өгөгдөл нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- 1) Агентлагийн нэр
- 2) Агентлагийн бүртгэлийн код
- 3) Агентлагийн хаяг
- 4) Агентлагийн веб хаяг
- 5) Агентлагийн бүлэг

#### **§ 20. ТМСУАМС-ийн холбоо барих этгээдийн бүртгэлийн сан**

(1) ТМСУАМС болон түүний үйлчилгээнд бүртгүүлсэн өгөгдлийн сангийн холбоо барих этгээдийн тухай мэдээллийг ТМСУАМС-ийн холбоо барих этгээдийн талаарх дэд-бүртгэлийн санд оруулна.

(2) ТМСУАМС-ийн холбоо барих этгээдийн дэд-бүртгэлийн санд оруулах холбоо барих этгээдийн ерөнхий мэдээлэл нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- 1) холбоо барих этгээдийн албан ажил
- 2) холбоо барих этгээдийн нэр, овог
- 3) холбоо барих этгээдийн тодорхойлолт

- 4) ТМСУАМС-ийн хүрээнд холбоо барих этгээдийн эдлэх эрх
- 5) холбоо барих этгээдийн эдлэх эрхийн хүчинтэй хугацаа, эрхийн хүчинтэй байх статус
- 6) тухайн агентлагт холбоо барих этгээдийн гүйцэтгэх үүрэг
- 7) холбоо барих этгээдийн үүрэг хариуцлагын төвшинг илтгэсэн тэмдэглэгээ
- 8) холбоо барих этгээдийн э-мэйл хаяг, утасны дугаар

#### **§ 21. ТМСУАМС-ийн зөвшөөрлийн дэд-бүртгэлийн сан**

(1) ТМСУАМС-ийн хүрээнд олгосон зөвшөөрөлтэй холбоотой өгөгдлийг ТМСУАМС-ийн зөвшөөрлийн дэд-бүртгэлийн санд оруулна.

(2) ТМСУАМС-ийн зөвшөөрлийн дэд-бүртгэлийн санд оруулах ёстой зөвшөөрөлтэй ерөнхий өгөгдөл нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- 1) Зөвшөөрөл олгох агентлагийн нэр
- 2) Зөвшөөрөл олгогдох өгөгдлийн сангийн нэр
- 3) Зөвшөөрөл олгосон шийдвэр
- 4) Зөвшөөрөл олгосон шийдвэрийн огноо
- 5) Засвар хийх буюу нэмэлт өөрчлөлт оруулах нөхцөл
- 6) Зөвшөөрөл олгосон агентлагийн тайлбар, тайлбар хийсэн огноо
- 7) Зөвшөөрөл олгосон тухай тайлбар эсхүл зөвшөөрөл олгохоос татгалзсан шалтгаан
- 8) Зөвшөөрлийн төрөл

#### **§ 22. ТМСУАМС-ийн Х-Тее-д интерфейс хийх дэд-бүртгэлийн сан**

(1) Х-Тее-д интерфейс хийхтэй холбоотой өгөгдлийг ТМСУАМС-ийн Х-Тее-д интерфейс хийх дэд-бүртгэлийн санд оруулна.

(2) ТМСУАМС-ийн Х-Тее-д интерфейс хийх дэд-бүртгэлийн санд оруулах шаардлагатай Х-замд холбох тухай ерөнхий өгөгдөл нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- 1) Х-Тее-д интерфейс хийх эсхүл Х-Тее-д интерфейс хийх орчны туршилтын өгөгдөл
- 2) Х-Тее-д интерфейс хийх эсхүл Х-Тее-д интерфейс хийх орчны туршилтийн төрлүүд
- 3) Агенллаг, түүний хамгаалагдсан сервер эсхүл өгөгдлийн сан Х-Тее-д интерфейс хийсэн эсхүл Х-Тее-гийн орчны туршилт хийсэн огноо

### **§ 23. ТМСУАМС-ийн өргөдлийн дэд-бүртгэлийн сан**

(1) ТМСУАМС-ээр дамжуулан гаргасан өргөдлүүдийн өгөгдлийг ТМСУАМС-ийн өргөдлийн дэд-бүртгэлийн санд оруулна.

(2) ТМСУАМС-ийн өргөдлийн дэд-бүртгэлийн санд оруулах шаардлагатай өргөдлүүдийн ерөнхий өгөгдөл дараах бүтэцтэй байна. Үүнд:

- 1) Өргөдлийн төрөл
- 2) Өргөдлийн төлөв байдал
- 3) Өргөдлийн маягт бөглөсөн огноо
- 4) Өргөдөл гаргагчийн мэдээлэл
- 5) Өргөдлийн агуулга

### **§ 24. ТМСУАМС-ийн мэдэгдлийн бүртгэлийн сан**

(1) ТМСУАМС-ээс гаргасан эсхүл хүлээн авсан мэдэгдэл болон мэдэгдэл илгээх журмын тухай өгөгдлийг ТМСУАМС-ийн мэдэгдлийн дэд-бүртгэлийн санд оруулна.

(2) ТМСУАМС-ийн мэдэгдлийн дэд-бүртгэлийн санд оруулах шаардлагатай мэдэгдэлтэй холбоотой ерөнхий өгөгдөл нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- 1) Мэдэгдлийн төрөл
- 2) Мэдэгдэл хүлээн авагч
- 3) Мэдэгдлийг илгээгч
- 4) Мэдэгдлийг дамжуулан илгээсэн хугацаа
- 5) Мэдэгдлийн агуулга

### **§ 25. ТМСУАМС-ийн үйлчилгээний дэд-бүртгэлийн сан**

(1) ТМСУАМС-д бүртгэгдсэн өгөгдлийн сангийн үзүүлэх үйлчилгээ, түүний дотор Х-Тее үйлчилгээ болон өгөгдлийн сангийн үзүүлж буй бусад веб үйлчилгээтэй холбоотой өгөгдлийг ТМСУАМС-ийн үйлчилгээний дэд-бүртгэлийн санд оруулна.

(2) ТМСУАМС-ийн үйлчилгээний дэд-бүртгэлийн санд оруулах үйлчилгээтэй холбоотой өгөгдөл нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- 1) Үйлчилгээний нэр
- 2) Үйлчилгээний код
- 3) Үйлчилгээний утгачилсан тайлбар
- 4) Үйлчилгээ үзүүлэх зарчим, түүний дотор төрөл бүрийн үйлчилгээний бүлгүүдэд зориулагдсан нийтийн үйлчилгээний талаарх мэдээлэл, ажиллах цагийн талаарх

үйлчилгээний төвшний үзүүлэлтүүд, хэрэглэгчийн асуултад хариу өгөх хугацаа, сар тутам ашиглах дундаж боломж, нэг тасралтын үргэлжлэх дээд хугацаа, найдвартай байдал, ажлын ачаалалын дээд хэмжээ

- 5) Үйлчилгээний статус
- 6) Үйлчилгээний төрөл
- 7) Үйлчилгээг хэрэглэгчийн бүлэг
- 8) Хувийн өгөгдөл боловсруулдаг эсэх
- 9) Хувийн нууц өгөгдлийг боловсруулдаг эсэх
- 10) Үйлчилгээний аюулгүй байдлын ангилал
- 11) Үйлчилгээний аюулгүй байдлын төвшин
- 12) Үйлчилгээний хэрэглэгчид
- 13) уг үйлчилгээг бусад үйлчилгээ, мэдээллийн системд холбосон байдал
- 14) Талбарт үйлчилгээнд холбогдсон байдал
- 15) Үйлчилгээний оролт, гаралтын утгачилсан тайлбар (тухайн хэсгийн нэр томъёоны лавлагаа хэлбэрээр);
- 16) Үйлчилгээний нэрийн өгөгдөл
- 17) Үйлчилгээтэй холбоотой үүссэн асуудал, түүнийг хянах, хэрэглэхтэй холбоотой статистик өгөгдөл

#### **§ 26. ТМСУАМС-ийн ангиллын дэд-бүртгэлийн сан**

Нийтийн өгөгдлийн тухай хуулийн 43 (1)-т заасан Журамд үндэслэн тогтоосон ангиллын талаарх өгөгдлийг ТМСУАМС-ийн ангиллын дэд-бүртгэлийн санд оруулна.

The data concerning the classifications established based on the Regulation provides in clause 43 (1) of the Public Data Act shall be entered in the RINA sub-register of classifications.

#### **§ 27. ТМСУАМС-ийн утгачилсан талбарын дэд-бүртгэлийн сан**

(1) Төрийн мэдээллийн системд ашигласан утгачилсан талбаруудын талаарх өгөгдлийг ТМСУАМС-ийн утгачилсан талбарын дэд-бүртгэлийн санд оруулна.

(2) ТМСУАМС-ийн утгачилсан талбарын дэд-бүртгэлийн санд оруулах шаардлагатай талбаруудын ерөнхий өгөгдөл дараах бүтэцтэй байна. Үүнд:

- 1) утгачилсан талбарын нэр
- 2) утгачилсан талбарын тайлбар

(3) ТМСУАМС-ийн утгачилсан талбарын дэд-бүртгэлийн санд оруулах утгачилсан талбарын толь бичгүүдийн өгөгдөл дараах бүтэцтэй байна. Үүнд:

- 1) Толь бичгийн хувилбар
- 2) Толь бичгийн өмнөх хувилбар
- 3) Толь бичгийн компьютерээр уншиж болох хувилбар (OWL).

(4) ТМСУАМС-ийн утгачилсан талбарын дэд-бүртгэлийн санд оруулах шаардлагатай утгачилсан талбарын толь бичгүүдийн өгөгдөл дараах бүтэцтэй байна. Үүнд:

- 1) Нэр томъёоны тодорхойлолт (URL);
- 2) Нэр томъёоны нэршил
- 3) Нэр томъёоны тайлбар
- 4) Тухайн нэр томъёо бусад нэр томъёотой холбогдох байдал

#### **§ 28. ТМСУАМС-ийн үнэн зөв байдал**

- (1) Өгөгдөл оруулж буй өгөгдлийн сангийн ерөнхий хариуцагч ТМСУАМС-д оруулсан өгөгдлийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдлыг хангах үүрэгтэй.
- (2) ТМСУАМС-д бүрэн бус эсхүл буруу өгөгдөл оруулсан эсхүл тийм алдаа илэрсэн тохиолдолд өгөгдөл оруулагч алдаа гарсныг мэдсэн буюу мэдэх боломжтой хугацаа өнгөрснөөс хойш ажлын 3 өдрийн дотор нэмэлт өөрчлөлт хийх үүрэгтэй.

#### **§ 29. ТМСУАМС-ийн өгөгдлийг ашиглах**

Хуулиар хязгаарласан буюу хууль тогтоомжид үндэслэн хязгаарласнаас бусад тохиолдолд олон нийт ТМСУАМС-ийн өгөгдлийг ТМСУАМС-ийн веб интерфэйсээр дамжуулан ашиглах боломжтой байна.

#### **§ 30. ТМСУАМС-ийн аюулгүй байдлын ангилал ба төвшин**

- (1) ТМСУАМС-ийн аюулгүй байдлын дараахи ангилал байна. Үүнд:
  - 1) S1-өгөгдлийн нууцлал
  - 2) T2-өгөгдлийн бүрэн бүтэн байдал
  - 3) K2-өгөгдлийг ашиглах боломж
- (2) ТМСУАМС нь аюулгүй байдлын дундаж төвшинтэй (M) байна.

#### **§ 31. ТМСУАМС-д өгөгдөл оруулахад тавигдах шаардлага**

- (1) ТМСУАМС-д өгөгдлийг электрон аргаар оруулах бөгөөд дараах боловсруулах явцын дагуу явагдана. Үүнд:

- 1) X-Тее-д интерфейс хийх болон интерфейсийн үйлдлүүдийн гүйцэтгэлтэй холбоотой өргөдлийг боловсруулах,
- 2) өгөгдлийн сангийн баримт бичгийн зөвшөөрөл
- 3) Өгөгдлийн сангийн талаар ТМСУАМС-д оруулсан өгөгдлийн бүтцийн өөрчлөх
- 4) Өгөгдлийн сангийн бүртгэл
- 5) Ангилал, түүнийг өөрчлөх зөвшөөрөл
- 6) Ангилал үүсгэх
- 7) Өгөгдлийн сангийн үйлчилгээг сайжруулж, ашиглах зорилгоор өргөдөлийг хянан үзэх

(2) Боловсруулах үйл явцын үе шат бүрд шаардлагатай өгөгдлийн бүтцийг ТМСУАМС-д өгөгдлийг оруулах бүрт тодорхой заах ёстой.

(3) Өгөгдөл оруулагч этгээд нь өгөгдлийн сантай холбоотой өгөгдлийг оруулах, засварлахад шаардлагатай нэвтрэх эрхийг олгох үүрэгтэй.

(4) Мэдээлэл оруулах этгээд X-Тее-тэй интерфейс хийсний дараа, ТМСУАМС-ийн цаашдын боловсруулах явц нь X-Тее-гийн мэдээлэл оруулах үйлчилгээг ашиглан явагдана.

### **§ 32. ТМСУАМС-ийн өгөгдлийг архив шилжүүлэх**

ТМСУАМС-ийн өгөгдлийг Архивын хуульд заасан журмын дагуу архивт шилжүүлнэ.

## **5-Р БҮЛЭГ**

### **Хэрэгжүүлэх заалтууд**

### **§ 33. Өгөгдлийн сангийн улсын бүртгэлд бүртгэгдсэн өгөгдлийн сангуудтай уялдуулах нь**

(1) Өгөгдлийн сангийн улсын бүртгэлд бүртгэгдсэн өгөгдлийн сангуудыг 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар ТМСУАМС-д шилжүүлсэн гэж үзнэ.

(2) Дэд хэсэг (1)-г дурдсан өгөгдлийн сангийн ерөнхий хариуцагчид өгөгдлийн сангийн улсын бүртгэлээс ТМСУАМС-д шилжүүлсэн өгөгдлийн бүтцийг 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө шинэчилсэн байна.

(3) Өгөгдлийн сангийн ерөнхий хариуцагч өгөгдлийн сангийн баримт бичгийг 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор бэлтгэсэн байна. § 27-д дурдсан утгачилсан тайлбарын

өгөгдлийг ТМСУАМС-д 2009 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө оруулсан байна. Өгөгдлийн сангийн баримт бичигт §§ 6- 8-д заасан журмын дагуу зөвшөөрөл олгоно.

(4) Хүндэтгэх шалтгааны улмаас ТМСУАМС-д өгөгдлийн сангийн баримт бичгийг 2008 оны 7-р сарын 1 гэхэд боловсруулж, оруулаагүй тохиолдолд ерөнхий хариуцагч энэ тухай өргөдлийг өгөгдлийн сангийн баримт бичгийг бэлтгэх хуваарийн хамт Эдийн засаг, харилцаа холбооны яаманд 6-р сарын 1-ний өдрөөс өмнө гаргана.

#### **§ 34. Өгөгдлийн сангийн улсын бүртгэлд бүртгүүлээгүй өгөгдлийн санг ТМСУАМС-д бүртгүүлэх**

(1) Энэхүү журам хүчин төгөлдөр болохоос өмнө үүсгэсэн бөгөөд өгөгдлийн сангийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй өгөгдлийн сангийн ерөнхий хариуцагч уг өгөгдлийн сангийн баримт бичгийг 2008 оны 7-р сарын 1 гэхэд боловсруулж, ТМСУАМС-д бүртгүүлнэ. Утгачилсан тайлбартай холбоотой өгөгдөл ба 27-р зүйлд заасан өгөгдлийг 2009 оны 7-р сарын 1-нээс өмнө ТМСУАМС-д оруулна.

Өгөгдлийн сангийн баримт бичигт §§ 6-13-д заасан журмын дагуу зөвшөөрөл олгож, бүртгэнэ.

(2) Хүндэтгэх шалтгааны улмаас ТМСУАМС-д өгөгдлийн сангийн баримтжуулалтыг 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр гэхэд боловсруулж, оруулаагүй тохиолдолд ерөнхий хариуцагч өгөгдлийн санг баримтжуулах өргөдлийг түүнийг боловсруулах хуваарийн хамт Эдийн засаг, харилцаа холбооны яаманд 6 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө гаргана.

#### **§ 35. ТМСУАМС-ийн бүрэлдэхүүн хэсгүүдийг ашиглах**

Асуудал, хүндрэлийг шийдвэрлэх ТМСУАМС-ийн хэрэглэгчийг дэмжих систем, засвар өөрчлөлтийг удирдах систем болон хяналтын системийг 2009 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө ашиглаж эхэлнэ.

1 RT = *RiigiTeataja*= Төрийн сонин

1 RT = *RiigiTeataja*= State Gazette